

## **ДОТООД ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБАНЫ 2024 ОНЫ ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН**

Дотоод хяналт, шинжилгээний алба нь 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд компанийн газар, хэлтсүүдийн үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ үнэлгээ хийж, эрсдэлийг тодорхойлох, бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр албан даалгавар, зөвлөмж өгч, гүйцэтгэх удирдлагыг мэдээллээр ханган, шийдвэр гаргах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн ажиллалаа.

2024 онд Стратеги санхүү борлуулалтын газрын Санхүү бүртгэлийн хэлтэс, Борлуулалтын хэлтэс, Маркетингийн хэлтэст, орон нутгийн газруудаас Хэнтий, Багануур, Архангай, Завхан, Дундговь, Өмнөговь аймгийн газруудын 2023, 2024 оны зорилтот түвшний болон үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, үр дүн, Гүйцэтгэх захиралтай байгуулсан гэрээний хэрэгжилтэд хяналт, шинжилгээ үнэлгээ хийж гүйцэтгэсэн.

Төлөвлөгөөт ажил, хяналт, шинжилгээ үнэлгээний хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

1. Хяналтаар нийт Улаанбаатар хотын газрын 3 хэлтэс, орон нутгийн 6 аймгийн газрын 23 сум, 5 Радио релейны станцын байр талбай, цамхгийн ашиглалт, техникийн бүрэн бүтэн байдал, техникийн ашиглалт үйлчилгээ, ХАБЭА-н нөхцөл байдал, компанийн болон төслийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлуудтай газар дээр нь танилцан, мэргэжил, арга зүйгээр ханган, зөвлөмж, туслалцаа үзүүлэн ажиллалаа.

2. Тайлант хугацаанд хяналт шалгалтаар ажилласан төвийн болон орон нутгийн газруудад холбогдох зөвлөмж, албан даалгавруудыг хүргүүлэв.

3. 2023 онд хяналт, шинжилгээ үнэлгээ хийгдсэн газруудаас өгөгдсөн албан даалгавар, зөвлөмжийн биелэлтийн тайланг хүлээн авч, биелэлт, үр дүнд хяналт, үнэлгээ хийсэн.

4. Компанийн 2024 оны Шилэн дансны цахим системийн хөтлөлт, Шилэн дансны тухай хууль болон холбогдох дүрэм, журмын хэрэгжилтэд улирал тутам хяналт хийж, ЗГХЭГ болон ЦХИХХЯ-д тайланг хүргүүлж байна.

5. Компанийн 2024 оны санхүүгийн тайлангийн аудитад 2024 оны хяналт, шинжилгээ үнэлгээний ажлын төлөвлөгөө, тайлан, дүгнэлт, гаргасан албан даалгавар, биелэлтийн тайланг гүйцэтгэх захиралд танилцуулсан.

6. Аудиторууд ISO37001 Авлигын менежментийн тогтолцооны сургалтад 5 ажилтан хамрагдаж, Дотоод аудиторын гэрчилгээ авсан.

7. Төв компанийн болон орон нутгийн газруудын удирдлагууд, ерөнхий инженер, ИТА, санхүүгийн ажилтнууд, ялангуяа шинээр томилогдсон ажилтнуудын мэргэжил, ур чадвар, хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, сургаж дадлагажуулах, зөвлөн туслах ажлыг хийж гүйцэтгэсэн.

**Дотоод хяналт, шинжилгээний алба**